

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

ОРШИЛ	3
БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	4
I.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
I. 2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ	5
I. 3. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ.....	5
БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
II.1. ЛАНДШАФТ	8
II.2. ФИЗИК-ГАЗАРЗҮЙ.....	8
II.3. УУР АМЬСГАЛ, АГААРЫН ЧАНАР	8
II.4. УСАН ОРЧИН	8
II.5. ХӨРСӨН БҮРХЭВЧ.....	9
II.6. УРГАМЛАН НӨМРӨГ	9
II.7. АМЬТНЫ АЙМАГ.....	9
II.8. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ	9
БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	11
III.1. АГААРЫН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	11
III.2. ГАЗРЫН ГАДАРГА БОЛОН ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ.....	11
III.3. УСНЫ НӨӨЦӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ.....	11
III.4. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	12
III.5. АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	12
III.6. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛСТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	12
III.7. ТӨСЛӨӨС ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	13
III.8. ТӨСЛӨӨС НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ.....	13
БҮЛЭГ IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	14
БҮЛЭГ V. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
V.I. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
5.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
10.1.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18
10.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	19
10.1.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
10.1.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
10.1.6. Тэрбум мод тарих төлөвлөгөө	19
10.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
10.1.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	21
10.1.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	22
10.1.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	22
10.1.11. Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах хуваарь	25
X.II. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ.....	26
БҮЛЭГ XI. ГОЛ ҮР ДҮНГҮҮД БА НЭГДСЭН ДҮГНЭЛТ	27
XII. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	28



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1. Төслийн ерөнхий мэдээлэл	4
Хүснэгт № 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбицол.....	5
Хүснэгт № 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
Хүснэгт № 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт № 5. Тэрбум мод тарих төлөвлөгөө	20
Хүснэгт № 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт № 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт № 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	22
Хүснэгт № 9. Мониторингийн цэгүүд	23
Хүснэгт № 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	24
Хүснэгт № 11. БОМТ-ий хэрэгжилтийг тайлагнах хуваарь	25
Хүснэгт № 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	26

ОРШИЛ

“Баярсгоулд” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт орших MV-018764 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий Бөөрөлжүүтийн гол алтны шороон болон үүсмэл ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах, тэрбум мод үндэсний хөтөлбөр, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Энэхүү төслийн БОННУ нь 2026 оны 08-р сарын 07-ны өдөр батлагдсан бөгөөд БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хүртэл хугацаанд БОННУ-д тусгасан ажлуудыг бүрэн хэрэгжүүлж амжихгүй байх магадлалтай болохыг анхаарна уу.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 32,980,000 төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.




БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

I.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт № 1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр	Бөөрөлжүүтийн гол алтны шороон болон үүсмэл ордыг ил аргаар ашиглах төсөл
Ашигт малтмалын төрөл	Алтны шороон болон үүсмэл
Төслийн байршил	Өвөрхангай аймгийн Уянга сумын Бөөрөлжүүт багийн нутаг дэвсгэрт Уянга сумын төвөөс хойш 9 км-т байрладаг.
Төсөл хэрэгжүүлэгч	“Баярсгоулд” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	1011008128
Регистрийн дугаар	5099854
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Өвөрхангай, Уянга, 6-р баг, Бөөрөлжүүт, 0 тоот Утас: 99193381 И-мэйл хаяг: bayarsgold@gmail.com
Тусгай зөвшөөрөл	АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 387 тоот шийдвэрээр 350.91 гектар талбай бүхий MV-018764 тоот тусгай зөвшөөрлийг “Баярсгоулд” ХХК-д нөхөн олгосон (Анх олгосон огноог 2008.05.16 тооцох, MR-013713). Улмаар тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн буцаан өгөх 2015 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн 629 тоот шийдвэрийн дагуу 223.47 га талбай хасагдаж 127.44 га талбай үлдсэн байна. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3 заалтын дагуу талбайг багасгах шийдвэрийн дагуу 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 110 тоот шийдвэрээр 110.97 га талбай үлдсэн байна.



Зураг № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн агаар сансрын байрзүйн зураг

- Талбайн нэр: Бөөрөлжүүтийн гол-1



ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-018764
- Трапецын номенклатур: L-48-49-Б
- Талбайн нийт хэмжээ: 110.97 га.

Хүснэгт № 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбицол

Цэгийн дугаар	Газарзүйн солбицол					
	Уртраг			Өргөрөг		
	Град	мин	сек	Град	мин	сек
1	102	14	55.64	46	32	45.79
2	102	14	17.97	46	32	51.73
3	102	14	25.82	46	32	39.83
4	102	14	42.45	46	32	34.58
5	102	14	46.78	46	32	28.53
6	102	14	48.88	46	32	20.87
7	102	14	52.59	46	32	18.8
8	102	14	55.74	46	32	15.7
9	102	14	59.26	46	32	13.16
10	102	15	11.38	46	32	8.98
11	102	15	15.6	46	32	3.32
12	102	15	21.81	46	32	2.17
13	102	15	25.82	46	32	0.68
14	102	15	26.8	46	31	57.57
15	102	15	26.79	46	31	53.58
16	102	15	32.32	46	31	51.26
17	102	15	36.2	46	31	45.65
18	102	15	43.64	46	31	45.65
19	102	15	43.64	46	32	16.65
20	102	15	19.64	46	32	16.65
21	102	15	19.64	46	32	32.65
22	102	14	55.64	46	32	32.65

I. 2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 387 тоот шийдвэрээр 350.91 гектар талбай бүхий MV-018764 тоот тусгай зөвшөөрлийг “Баярсгоулд” ХХК-д нөхөн олгосон (Анх олгосон огноог 2008.05.16 тооцох, MR-013713).

Улмаар тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн буцаан өгөх 2015 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн 629 тоот шийдвэрийн дагуу 223.47 га талбай хасагдаж 127.44 га талбай үлдсэн байна. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3 заалтын дагуу талбайг багасгах шийдвэрийн дагуу 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 110 тоот шийдвэрээр 110.97 га талбай үлдсэн байна.

I. 3. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Уурхайн одоогийн байдал, үлдэгдэл нөөцийн тооцоо

2023-2024 оны нэмэлт хайгуулын ажлын үр дүнд ордын хэмжээнд бодитой (В) зэрэглэлээр шлихээр 9.75 кг (химийн цэврээр 8.81 кг) алт, боломжтой (С) зэрэглэлээр шлихээр 15.85 кг (химийн цэврээр 14.32 кг), нийт бодитой болон боломжтой (В+С)



ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

зэрэглэлээр шлихээр 25.60 кг (химийн цэврээр 23.13 кг) алтны нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

Уул-техникийн нөхцөл: Орд нь бага гүний тогтоцтой олборлоход хялбар, дунд зэргийн агуулгатай бөгөөд олборлолт явуулахад уул техникийн хүндрэлгүй байна. Тусгай зөвшөөрөлийн талбайн гадаргуу нь 1°-2° налуутай байна.

Алт агуулсан элсний давхарга нь аллюви-пролювийн гаралтай хайрга, хайрганцар агуулсан, шавранцар зонхилсон хурдсаас тогтоно. Хучаасын дундаж зузаан хамгийн их хэсэгтээ 7.4 м, хамгийн бага хэсэгтээ 4.4 м байна.

Ордын үүсмэл ордын овоолгууд 2-12 м-ийн харилцан адилгүй өндөртэй, хамгийн урт хэсэгтээ баруун хойноос зүүн урагш 50-113 м-ийн урттай, 15-54 м-ийн өргөнтэй дээрээс хагас зууван, конус хэлбэрийн овоолгууд байна.

Анхдагч шороон ордын хайгуулын өрөмдлөгийн ажлын явцад цооногуудаас ус илрээгүй бөгөөд энэ хэсэгшил нь өмнөх жилүүдэд ашиглаж байсан уурхайн улны түвшнээс дээш дэнжийн хэсэгт байрлаж байгаа тул шүүрлийн усны түвшинд хүрээгүй гэж үзсэн байна. Үүсмэл ордын овоолгуудын ёроол хэсгээс 1-3.5 м гүнтэй шурф малталтын үед овоолгуудын хананаас шүүрлийн ус илрээгүй байна.

Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц

Ил уурхайн хүрээнд бодитой (В) зэрэглэлээр 56.08 мян.м³ элс буюу шлихээр 14.01 кг (химийн цэврээр 12.63 кг) алт, боломжтой (С) зэрэглэлээс 235.81 мян.м³ элс буюу шлихээр 15.83 кг (химийн цэврээр 14.30 кг) алт, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 291.89 мян.м³ элс буюу шлихээр 29.84 кг (химийн цэврээр 26.94 кг) алт ил уурхайн хүрээгээр олборлогдоно. Нийт ил уурхайн хүрээн дотор 291.89 мян.м³ элс буюу 26.94 кг алт, 201.24 мян.м³ хөрс орж байна.

2026 онд явагдах уулын ажил, ажиллах горим

2026 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр үүсмэл ордын 5С, 6-С, 7-С, 8-С овоолгуудын үйлдвэрлэлийн нөөцөөр хими цэврээр 9.36 кг алт бүхий 163.14 мян.м³ элсийг угаан баяжуулна.

Уурхайн үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын хүндрэл, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдийг тооцсон. Хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Үржил шимт хөрс хуулалт

Ил уурхайн үйл ажиллагаа нь шимт хөрсийг түрж хуулах хүрээний дагуу овоолох, хөрсийг ухаж ачих тээвэрлэх овоолох, элсийг ухаж ачих, тээвэрлэн түр овоолгод овоолох, овоолгыг хэвгийжүүлэх гэсэн үндсэн процессоор явагдана.

Овоолго

Ил уурхайд SD-23 маркийн 5.4 м³ утгуурын багтаамжтай бульдозероор овоолгын үлдэц асгацыг түрж хэвгийжүүлэхээр ашиглана. Уурхайн жил бүрийн уулын ажлын хэмжээнээс хамааруулж автосамосвалын асгах үед үлдэц асгацын 50% тооцон ажлын хэмжээг тооцлоо.

Ус таталт



ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ашиглалтын хугацаа. Бөөрөлжүүтийн гол алтны шороон болон үүсмэл ордын 1 дэх жилд олборлох 8-В блок нь усан сан бүхий энгийн хамгаалалтын бүсэд давхцалтай татмын хэсгийн орд учир тухайн хэсэгт ил уурхайн усны тооцоог хийж гүйцэтгэлээ. 2 дах жилд олборлох шороон орд нь дэнжийн хэсэгт байрлах ба цооногийн мэдээлэлээр ус илрээгүй байна. Үүсмэл ордын овоолгуудын ёроол хэсгээс 1-3.5 м гүнтэй шурф малталтын үед овоолгуудын хананаас шүүрлийн ус илрээгүй байна.

Уурхайд орж ирэх шүүрлийн усыг 1К 65-50-160а насосоор соруулж технологийн усанд ашиглана.

Угаан баяжуулах хэсэг

Технологийн схемийн хувьд скруббер-бутар, шлюз, кнелсон концентратор болон баяжуулах ширээгээр баяжуулахад 0.28%-ийн гарцтай, 85.76%-ийн металл авалттай байна.

Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

Бөөрөлжүүтийн гол алтны шороон болон үүсмэл ордоос нийт 0.10 гр/м³ агуулгатай, 169.1 мян.м³ элс олборлох бөгөөд үүнийг гравитацийн аргаар баяжуулж, 85.76 хувийн металл авалттайгаар 8.1 кг алт үйлдвэрлэн борлуулна.

Ажилчдын бүтэц бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт

Ажилчдын орон тоог төслийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай техник технологи, төслийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн тоо нэг бүрийг харгалзан тооцлоо. Төслийн хүчин чадлыг бүрэн ашиглахад хангалттай тооны ажилчдыг тусгаж өгсөн бөгөөд уурхайн ажлын горим 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Сум орон нутгийн иргэдийг ажилтай, орлоготой болгох, ажилчдыг аюулгүй таатай орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлж ажиллахыг зорьж байна.

Төсөлд шаардлагатай орон тооны хувьд захирал, уурхайн дарга, ашиглалтын геологи, байгаль орчны мэргэжилтэн болон нярав, нягтлан зэргийг үндсэн ажилтанаар, бусад орон тооны хувьд гэрээт ажилтан авч ажиллуулахаар төлөвлөсөн.

БАЙГАЛЬ ОРЧНЫ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

II.1. Ландшафт

Хангай-Хэнтийн уулархаг их мужийн, Хангайн хөмбөн-цулдам уулт өндөрлөгийн мужийн, Хангайн уулт өндөрлөгийн зүүн хэсгийн дундаж өндөр цулдам уул бүхий ар хажуугийн ой, хээрийн дэд муж, Бат-Өлзийтийн налуулаг ой, умардын хуурай хээр, хээр, ойн бүсэд хамаарна.

II.2. Физик-газарзүй

Газар зүйн хувьд Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хангайн муж Хангайн гол нуруудын тойрогт хамаарна. (Монголын Үндэсний Атлас 1990, 2009). Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр, говь хосолсон мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой нутаг.

Газрын гадарга нь Хангайн нурууны Жаргалант, Тооройт, Ив зэрэг далайн түвшнээс дээш 3,230 м өндөр өргөгдсөн уулс Таац, Онгийн хөндий, Найман нуур, Битүүт, Хятнуур, Шурангийн улаан цохио зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудтай бөгөөд үнэмлэхүй өндөр нь 1,700-3,305 м далайн түвшнээс дээш өргөгдсөн. Хангайн нурууны уулс шинэсэн ойгоор бүрхэгдсэн.

II.3. Уур амьсгал, агаарын чанар

Төслийн талбай нь Монгол орны уур амьсгалын мужлалтын чийглэгдүү хүйтэвтэр зунтай бүсийн хахир өвөлтэй мужид хамаарна.

Тусгай зөвшөөрлийн талбайд хамгийн ойр байрлах Арвайхээр станцын мэдээллээс авч үзэхэд эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж хэм нь $+2.1...+3.5^{\circ}\text{C}$ байдаг. Хамгийн хүйтэн сар нь нэгдүгээр сар бөгөөд агаарын үнэмлэхүй бага температур -30.6°C , хамгийн дулаан сар нь 7-р сар бөгөөд агаарын үнэмлэхүй их температур 36.2°C байна. Жилд дунджаар 270 мм хур тунадас унах бөгөөд өвлийн улиралд 1.5...2.5 мм, хаврын улиралд 1.5...9.7 мм, зуны улиралд 10.8...89.7 мм, намрын улиралд 7.2...68.9 мм-ийн хооронд хэлбэлздэг ба салхины хурд жилд дунджаар 3.5 м/с байдаг. Үндсэн хамгийн их утга нь 5 сард 4.7 м/с, хоёрдугаар их утга нь 9 сард 3.5 м/с ажиглагдсан бол үндсэн хамгийн бага утга нь 12 сард 2.5 м/с, хоёрдугаар бага утга нь 8 сард дунджаар 3.4 м/с тохиодог байна.

II.4. Усан орчин

Төслийн талбай нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарах бөгөөд Онги голын сав газарт байрлана. Энэ голын савд 1 дүгээр эрэмбийн сайр-горхи 171, тэдгээрийн дундаж урт 2.3 км, ус хурах дундаж талбай 7.8 км^2 , 2 дугаар эрэмбийн горхи 44, 3 дугаар эрэмбийн гол 9, 4 дүгээр эрэмбийн гол 2 байна.

Төслийн талбай орчимд хамгийн ойр урсан өнгөрөх гадаргын ус нь Бөөрөлжүүтийн гол байх бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайн баруун хилээр хойноос урагш чигт урсан өнгөрч Онгийн голд цутгадаг байна. Тусгай зөвшөөрлийн талбай нь усны сан бүхий газар, энгийн хамгаалалтын 200 м-ийн бүстэй 25.3 га газар давхцалтай байна.



БАЙГАЛЬ ОРЧНЫ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

II.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайд уулын хүрэн хөрс, аллювийн нугын хөрс тархсан байна. Хээрийн судалгаагаар 6 цэгт хөрсний зүсэлт хийсэн. Хөрсний агрохимийн 3 дээж, хөрсний хүнд металл 2 дээж, эрүүл ахуй 1 задлан шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүнгээр дээж-1,5,6 дунд дээж-2,3,4 нь сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламж дунд, цахилгаан дамжуулах чанар бага давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон хөдөлгөөнт калийн хангамжаар бага байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дунд байна. Хүнд металлын агууламжаар MNS5850:2019-д заасан хөрсөнд агуулагдах хүлцэх агууламжаас бага буюу хэтрээгүй байна.

II.6. Ургамлан нөмрөг

Тухайн бүс нутаг нь ургамал газарзүйн мужлалтын хувьд Евразийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн Хуурайдуу хэвшинжийн Хангайн зүүн өмнөд нам уулсын дэд мужид хамаарна. (Монголын Үндэсний Атлас II, 2009)

Бэлчээрийн хэвшинжийн хувьд шууд ашиглах бэлчээрийн дундаж өндөр ба нам уулын бэлчээрийн Алаг өвс-ботуульт хээрийн бэлчээр, өндөр уулыг бэлчээрийн уулын нугын ба нугат-хээрийн бушилз, улалж, ботуульт бэлчээрийн хэвшинж зонхилно. (Монголын Үндэсний Атлас II, 2009)

Төслийн талбай орчимд 2025 оны зуны улиралд хийсэн судалгаагаар нийт 17 овгийн 48 төрлийн 61 зүйл ургамал бүртгэгдсэн. Зүйлийн бүрэлдэхүүн дэх ургамлууд нь амин хэлбэрийн хувьд сөөг-2(3%), сөөгөнцөр-1(2%), олон наст зүйл-48(79%), нэг ба хоёр наст-7(11%) зэрэг ургамлууд бүрдүүлж байна.

II.7. Амьтны аймаг

Төсөл хэрэгжиж буй нутаг нь монгол орны хөхтөн амьтдын тархацын газарзүйн мужлалаар Монгол-Түвдийн муж, Монголын хээр ба ойт хээрийн дэд муж, 5-р тойрог буюу Хангайн тойрогт хамаарагдана. Төслийн талбай орчимд хээрийн болон өндөр уулын хөхтөний бүлгэмдэл тархсан байх бөгөөд зонхилогч бүлгэмдэл нь тарвага, оготно, огдой зэрэг байна. Мэрэгчдээс улирлын чанартай буюу өвөл ичдэг монгол тарвага, цайвар үлийч элбэг тархдаг бол жилийн турш идэвхитэй байдаг хадны барагчин, соёны барагчин элбэг тархдаг байна. (Монголын Үндэсний Атлас II, 2009)

Харин Монгол орны шувууны газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг мужын 10-р тойрог буюу Хангайн төв нурууны тойрогт хамаарна. Жигүүртний хувьд болжмор, ногтруу, хадны тагтаа, элээ түүнчлэн хон хэрээ, бүргэд бусад шувуу амьдардаг Мөлхөгчдөөс элбэг түгээмэл шинжтэй нь монгол бах, монгол гүрвэл байдаг бол шавьжнаас аалз, сохор хар, хэдгэнэ, царцаа, эрвээхэй болон бусад шулуун далавчтан байдаг.

Загасны газарзүйн мужаар Уулархаг азийн мужын нууруудын хөндийн ай савд хамаарагдана. Энэ ай савд жарга загас, алтайн шар сугас, сахалт эрээлж зэрэг зүйлүүд тархана.

II.8. Нийгэм, эдийн засаг

Өвөрхангай аймгийн Уянга сум Хангай, тал хээр хосолсон 313.9 кв.км нутаг дэвсгэртэй. Далайн түвшинээс дээш 1,700-3,305 м өргөгдсөн. Онги, Таац зэрэг Хангайн нуруунаас эх авсан томоохон голуудтай. Нутаг дэвсгэрийн 30 гаран хувийг ой мод



БАЙГАЛЬ ОРЧНЫ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

эзэлдэг. Хангайн нурууны уулс шинэсэн ойгоор бүрхэгдсэн, зүүн хойт хэсэгтээ хушин ойтой, нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр хосолсон. Хуурайдуу сэрүүн зунтай, хахир ширүүн өвөлтэй. Алт, эрдэнийн чулуу, хүрмэн чулуу зэрэг байгалийн баялагтай. Өндөр уулын бут, сөөг, хаг, хөвд өвс, өлөн алирс бүхий ойн уулсын бэл хөндийгөөр алаг өвс, жижиг үетэн, ерхөг голлосон ойт хээрийн ургамалтай. Буга, янгир, аргаль, угалз, бор гөрөөс, хүдэр, гахай, чоно, үнэг, хярс, мануул, шилүүс, өмхий хүрэн, тарвага, зурам, хэрэм, жирх зэрэг ан амьтантай үүнээс аргаль, угалз, гахай, хүдэр маш ховордсон. Янгир өсөж байгаа. 14 төрлийн жигүүртэн амьдардаг. Үүний дотроос хойлог, ятуу, ахууна, самрын бахираа нэн ховордсон. Бүргэд, тас, шонхор, сар зэрэг махчин шувууд бий. Олон төрлийн усны шувууд ирж зусдаг.

Хүн амын суурьшил нягт, голчлон газар тариалан болон мал аж ахуй эрхэлдэг, халх ястан голлон амьдардаг. Уянга сумын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 9,120 хүн амтай, нийт хүн амын 26.4% нь сумын төвд амьдардаг, 2,738 өрхтэй, үүнээс 93 өрх нь ганц бие өрх байна. Сумын хүн амын 30.6% нь 0-14 насны хүүхэд, 57.8% нь 15-54 насныхан, 11.6% нь 55-с дээш буюу ахмад настан байна. Нийт хүн амын 49.5% нь эмэгтэйчүүд, 50.5% нь эрэгтэйчүүд байна. Тус район нь зам харилцаа сайтай, өвөл, зуны аль ч улиралд бартаа саадгүй, сумын хэмжээнд ерөнхий боловсролын 3 сургуультай, сургуулийн өмнөх боловсролын 3 цэцэрлэгтэй, аж үйлдвэр, ХАА-н үйлдвэрлэлийн баазуудад ойр байрлана. Сумын төсвийн орлого 2024 оны жилийн эцсийн байдлаар 3,715.7 сая.төг байсан өмнөх оны мөн үеэс 143.4%-аар нэмэгдсэн байх бол төслийн зарлага 3,112.1 сая.төг байсан нь мөн адил өмнөх оны мөн үеэс 130.5%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна



ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

III.1. Агаарын орчинд үзүүлэх нөлөө

Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад суларсан нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх зэрэг сөрөг нөлөөлөл байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Төслийн талбайн дотоод тээвэрлэлтийг аль болох олон салаа зам гаргахгүйгээр тээвэрлэх,
2. Орчны агаарт ялгаруулах хорт утаа хийг багасгахын тулд техникийн засвар, үйлчилгээг тогтмол хийж байх.

III.2. Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө

Ил уурхайн аргаар үйл ажиллагаа явуулах учраас газрын гадаргад өөрчлөлт орно. Хөрс хуулалт, гадаад болон дотоод овоолго, баяжуулах үйлдвэр, ажилтнуудын түр амьдрах байр зэрэг бүхий л уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлнө.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Барилга байгууламж, овоолгын суурь зэргийн шимт хөрсийг тусад нь хуулан авч хураана.
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх,
3. Тээвэрлэлтийг явуулахдаа замын тогтсон маршрут гаргах, мөрдүүлэх, мөн хүнд даацын тээврийн хэрэгслийн зөөвөрт явах үеийн хурдыг тогтоох (хурдтай явах тусам тоосжилт нэмэгдэн техникт эвдрэл гарна), хяналт тавих,
4. Тогтсон маршрутын дагуу замын тоосжилт дарах усалгаа хийх,
5. Хатуу хаягдлыг ялган ангилж хадгалах, төвлөрсөн цэгүүдэд зайлуулах хэрэгтэй.

III.3. Усны нөөцөд үзүүлэх нөлөө

Технологийн онцлог нь гадаргын усыг ашиглах учраас гадаргын усны түвшин буурах, бохирдох нөлөөллийн эрсдэл байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Тус ордод ашиглах усыг Бөөрөлжүүтийн голын ус болон шүүрлийн усаар хангах юм. Голын ус болон шүүрлийн ус татах дамжуулах шугам хоолойн эх дээр баталгаажуулсан тоолуур суурилуулан усны хэрэглээнд хяналт тавин ажиллах шаардлагатай.
2. Ундны зориулалтаар хэрэглэх усны чанарт тогтмол хяналт шинжилгээ хийж байх.
3. Эргэлтийн усан сангуудаас алт угаан баяжуулсан бохир ус хөрсөнд нэвчихээс сэргийлж эргэлтийн усан сангийн ёроолыг ус үл нэвчүүлэх тусгай зориулалтын полиэтиленээр хучих шаардлагатай. Эргэлтийн усан сангаас ус алдаж болзошгүй тохиолдолд урьдчилсан арга хэмжээ авах, усан сангийн даланд хананы бэхлэгээ хийх, усан санг үерээс байнга хамгаалж байх.



ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

III.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө

Хөрс хуулалт, овоолго хийх, дотоод тээвэрлэлтийн явцад ургамлан бүрхэвч устаж дарагдахаар байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Олборлолт явуулсан талбайд утсан ургамлыг нөхөн сэргээж тарих,
2. Хавар намрын хуурайшилттай үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх.

III.5. Амьтны аймагт үзүүлэх нөлөө

Эерэг нөлөөллүүд

1. Амьтны аймгийн мониторинг нь энэ бүс нутаг орчмын амьтны аймгийн тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангах чухал ач холбогдолтой.

Сөрөг нөлөөллүүд

2. Хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дуу чимээ, замын тоос зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах зэрэг сөрөг нөлөөлөлтэй,
3. Олборлолт явуулж байгаа газарт мал, амьтан унах,
4. Хөрс хуулалтын үед үүссэн нүх, хөрсөнд орогнох, үүрлэх мэрэгч, мөлхөгч, шувуудын үүр ноохой сүйтгэгдэх зэрэг болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

Ажилчид болон нутгийн иргэдэд байгаль орчныг хамгаалах, тэр тусмаа амьтны аймгийн талаарх сургалт сурталчилгаа хийх, зэргэлдээх уурхайнууд, нутгийн иргэдтэй хамтарсан мониторинг сүлжээ бий болгох (гар утасны БАЙГАЛЬ АПП ашиглах.)

Бүс нутгийн биологийн төрөл зүйл, тоо толгойг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, иргэдийн төлөөлөл, байгаль орчны албаны ажилтантай байнга хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд тэдгээрт туслалцаа үзүүлэх, санал солилцох, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

III.6. Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх нөлөө

Төслийн талбайд 2015 онд гүйцэтгэсэн Палеонтологийн хайгуул судалгааны тайланд тусгаснаар талбайд энгийн аргаар хайгуул явуулахад ажиглалтын цэг АЦ. 1, 3, 5, 9, 10-ын орчим газраас эртний хөхтөн амьтдын биеийн янз бүрийн хэсгийн (толгойн яс, мөчний хэсэг, хөлийн тавхайн яс зэрэг) чулуужсан яс, АЦ. 14-өөс ховроор эртний ургамлын үлдэгдлүүдийг тус тус илрүүлсэн болно. Иймэрхүү үлдэгдэл ба бусад эртний амьтан, ургамлын олдвор талбайн бусад хэсгээс илрэх өндөр магадлалтай болохыг тогтоосон байна. Энэхүү ажил нь 2015 онд тусгай зөвшөөрлийн талбайг 350.91 га талбайн хэмжээнд байх үед хийгдсэн ажил бөгөөд үүнээс хойш тусгай зөршөөлийн талбайг хэсэгчлэн буцаан хүлээлгэж өгснөөр одоогийн байдлаар 110 га талбай үлдсэн байна. Иймд одоогийн ашиглаж буй тусгай зөвшөөрлийн 110 га талбайн хэмжээнд төслийн 2 дахь жилд дахин Палеонтологийн хайгуул судалгаа хийлгэхээр БОННУ-д тусгасан байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга



ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1. Хэрэв ашигт малтмал ашиглалтын явцад хүн малын яс, шавар ваар савны хагархай, янз бүрийн хүрэл, төмөр эдлэл, түүний хэлтэрхий, хугархай гэх мэт хүний гараар хийсэн ямар нэг эд өлгийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд орон нутгийн удирдлага, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж хамгаалалтанд авах ба дурдсан мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж малтлага судалгаа хийлгэхийг зөвлөж байна.

III.7. Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

Хөдөлмөрийн, ХАБЭА тухай хууль, бусад холбогдолтой дүрэм журам, стандартын шаардлагуудыг мөрдөх, дотоодын хяналтын журам аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг нийт ажилтнуудад мөрдүүлэх, хяналт тавих шаардлагатай.

III.8. Төслөөс нийгэм, эдийн засгийн байдалд үзүүлэх нөлөө

- Төслийн нөлөөллийн бүсэд төвлөрсөн суурьшил байхгүй,
- Төслийн үйл ажиллагааны үед орон нутагт ажлын байр бий болно,
- Орон нутгаас нийлүүлэх боломжтой хүнсний хангамж, ахуйн хангамж, түлш шатахуун нийлүүлэлт зэрэг материаллаг эрэлт үүснэ,
- Улс орны төсөвт мөнгөн хуримтлал бий болгоно,
- Мөн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг нийгэм эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай.



БҮЛЭГ IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт: Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагаа эхлээгүй үед хийгдэж байгаа учраас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл: Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга: Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБҮ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан



ГОЛ ЗОРИЛТ БА ХАМРАХ ХҮРЭЭ

байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

Байгаль хамгаалах төлөвлөгөө:

- ✓ Төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ
- ✓ Уул уурхайн төслийн хаалтын үед авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, хамрах хүрээ;
- ✓ БОМТ-г хэрэгжүүлэх хүний нөөц, БО-ны удирдлагын бүтэц зохион байгуулалт;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө;

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:

- ✓ Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;
- ✓ Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- ✓ Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

БОМТ-ний бүтэц: БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 7 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн товч танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө
7. Дүгнэлт



БҮЛЭГ V. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

V.1. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнөөр үүсэх тоосжилт болон тээврийн хэрэгсэлийн яндангаас ялгарах хорт хий байна гэж үзсэн. Мөн техник, тээврийн хэрэгсэлийн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ байна. Тоосжилтыг бууруулахын тулд замын тоосыг усаар дарах болон барьцалдуулагч бодис ашиглан тоосыг тодорхой хугацаанд барих зэргийг зөвлөмж болгосон. Тээврийн хэрэгсэлийн яндангаас ялгарах хорт хийг бага байлгахын тулд техник, тээврийн хэрэгслүүдийн оношилгоо, тохиргоо, засвар үйлчилгээг тогтмол хийх шаардлагатай. Дуу чимээний бохирдлоос ажилчдыг хамгаалах дуу чимээ багасгах чихэвчээр хангахыг зөвлөж өгсөн.

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд усыг ариг гамтай ашиглах, хурын усыг хуримтлуулж замын тоос дарахад ашиглахыг зөвлөмжилсөн. Мөн үер борооны усаар зөөгдөн элдэв хог хаягдлаар бохирдол үүсэхээс сэргийлж далан шуудуу барих шаардлагатай. Ус ашиглалтын бүртгэл хөтөлж, усны тайланг тогтмол гаргаж зохих газар нь хүргүүлж тайлагнах, ус ашиглалтай холбоотой гэрээ, зөвшөөрлийг авч, хүчинтэй хугацааг хянаж ажиллахаар төлөвлөсөн. Ахуйн шингэн хог хаягдлаар хөрс бохирдож газрын гүний ус бохирдохоос сэргийлж бага оврын цэвэрлэх байгууламжыг төлөвлөж өгсөн.

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд Шимт хөрсний хадгалалтыг стандартын дагуу хийж усалж арчилж байх, замын тэмдэг тэмдэглэгээг байршуулж түүний дагуу техник тээврийн хэрэгслийг зорчуулж байхыг зөвлөмжилж төлөвлөгөөнд тусгаж өгсөн.

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөлтийн дагуу хийж гүйцэтгэх, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх зэргийг зөвлөмжилж өгсөн. Мөн тоосжилтыг бага байлгах зорилгоор ногоон байгууламжийг ажилчдын хотхон орчимд бий болгож, арчилж байхаар төлөвлөлөө.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд ажилчид хууль бус ан агнуур хийхгүй байхад хяналт тавих, талбайн орчимд үзэгдсэн зэрлэг амьтдын бүртгэл хөтлөх, халдварт өвчин тарааж болзошгүй амьтад хог хаягдлын цэгт цугларахгүй байх арга хэмжээ авч тогтмол ачуулж зайлуулж ариутгал хийлгэж байх зэрэг ажлуудыг төлөвлөж өгсөн.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар									
1.	Уурхайн дотоод тээврийн замаас үүсэх тоосжилт	Барьцалдуулагч бодис ашиглаж дотоод тээврийн замыг услах	Дотоод тээврийн зам	метр	3,000	400	1,200,000	Хуурайшилт ихтэй өдрүүдэд	-Агаарын тухай хууль, -Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
2.	Дуу шуугиан ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх	Дуу шуугианы хэмжилт хийж, дуу, шуугиан бүхий машин механизмын үр ашиггүй ашиглалтыг багасгах. (Уг багажийг хэрэв БОШТЛ, “ОС МТ” ХХК зэргээс түрээслэвэл түрээсийн зардал 30,000 төг байна.)	Уурхайн орчим	ширхэг	30,000	1	30,000	Түрээсийн багаж ашиглан хэмжилт хийх	-MNS 12.1.06:1988 Хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартын систем. Дуу чимээний хамгийн өндөр түвшин. Аюулгүй байдлын шаардлага.
Гадаргын болон газрын доорхи ус									
1.	Усыг хэтрүүлэн ашигласны улмаас усны нөөц хомсдох, усны бохирдол, үер борооны усаар хог хаягдал зөөгдөн ус бохирдох	Гадаргын усны насос, дамжуулах хоолойд мэргэжлийн байгууллагаар тоолуур тавиулан баталгаажуулах.	Ус татах, дамжуулах хоолой, насос	ширхэг	500	1	500,000	2026 он	Усны тухай хууль, -Ус ашигласны төлбөр тооцох аргачлал (Засгийн газрын 2013 оны 327-р тогтоол)
2.		Тунаах нуурын усыг голын усанд алдахгүй байхын тулд далан шуудуу барих	Тунаах нуурын орчимд	метр	1,250	200	250,000	2026 он	
3.		“Эколог” ХХК-ийн бага оврын цэвэрлэх байгууламжыг байгуулах	АЦ-ийн Байгууламж	ширхэг	10,000,000	1	10,000,000	2026 он	
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг									
1.	Олон салаа зам үүссэний улмаас хөрсний үржил шим байхгүй болох, хөрс талхлагдах	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах	Дотоод тээврийн зам	ширхэг	30,000	5	150,000	9 сард	-Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, -MNS 4601:2011 Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүн. Техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо
2.	Шатах, тослох материал асгарч газрын хөрсөнд нэвчих, бохирдуулах	Засварын газрын талбайг хатуу хучилттай болгох.	Засварын газар	м²	6,250	56	350,000	2026 он	



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

									-Хог хаягдлын тухай хууль,
3.	Ургамлан бүрхэвч үгүй болсноор тоосжилт, цөлжилт үүсэх	Нутгийн ургамлын үрийг түүж бэлтгэх талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн зөвлөгөө авч орон нутгийн иргэд, уурхайн ажилчидыг дайчлан нутгийн үетэн ургамлын үрийг шимт хөрсний овоолгод ургуулж турших, үрийн нөөц бэлтгэх	Уурхайн орчмын ургамлан нөмрөг, шимт хөрсний овоолго	Нэгжээр хэмжих боломжгүй			2,500,000	2026 он	Ургамал хамгааллын тухай хууль Байгалийн ургамлын тухай хууль
Амьтны аймаг									
1.	Уурхайн ойр орчмын амьтад үргэх, дайжих, амьдрах орчин үгүй болох	Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр уурхайн ажилчид болон нутгийн иргэдтэй хамтран “Байгаль” аппликейшн ашиглаж амьтны мониторингийн судалгаа хийх, түүний хэрэгжилтийг хангуулахад анхаарч идэвхтэй ашиглагчдад урамшуулал олгох	Төслийн талбай орчимд нутгийн иргэд, уурхайн ажилчид	Нэгжээр хэмжих боломжгүй			500,000	2026 он	"Амьтны аймгийн тухай" хууль: 6.1.7 дахь заалт: үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх
2.	Мал амьтны гоц халдварт өвчин тархах	Ажилчдын тосгонд ариутгал халдваргүйжлийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Төслийн талбай орчим	удаа	50,000	1	50,000	9 сард	
3.	Төслийн үйл ажиллагааны явцад санаатай болон санамсаргүй байдлаар Бөөрөлжүүтийн голын усыг бохирдуулсан тохиолдолд Онги голд шууд цутгаж түүнд амьдрах амьтдад нөлөөлж болзошгүй	Тунаах нуурын усыг алдахгүй байх, далан шуудуу барих, саарал усыг голын усанд шууд нийлүүлэхгүй байх, Цэвэрлэх байгууламжаас гарсан цэвэршүүлсэн усанд шинжилгээ хийлгэж шаардлага хангасан тохиолдолд зам талбайн усалгаа, ногоон байгууламжын усалгаанд ашиглах	Тунаах нуур, Үерийн далан, Бага орвын цэвэрлэх байгууламж	Нэгжээр хэмжих боломжгүй			600,000	2026 он	
	Нийт						16,030,000		

10.1.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нийт төслийн хугацаанд дээрх талбайнуудад ашиглалтын үеийн буюу эвдэгдсэн газрын нөхөн сэргээлт болон хаалтын үеийн нөхөн сэргээлт гэж 2 төрлийн нөхөн сэргээлт хийгдэнэ. Ашиглалтын үеийн нөхөн сэргээлт нь төслийн 2 дахь жилээс эхлэн үе шаттайгаар хийгдэхээр төлөвлөж байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын 2019 оны А/181, А/458 дугаар хамтарсан тушаалын баталсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын дагуу төслийн үйл ажиллагаа дуусахаас 2 жилийн өмнө Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулж батлуулж ажиллах шаардлагатай.



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бөөрөлжүүтийн гол алтны шороон болон үүсмэл ордыг ил аргаар ашиглах төсөл нь дотоод овоолготой ашиглалтын системтэй тул техникийн нөхөн сэргээлтийн зардалд нөхөн дүүргэлт хийх зардал тооцогдоогүй тул ажлын хэмжээг түрж тэгшлэх талбайн хэмжээгээр буюу га-р тооцсон болно.

Төслийн эхний жил 2026 он байх бөгөөд бичиг баримтын бүрдэл хангах ажлаас шалтгаалан үйл ажиллагаа 2 орчим сар явагдах тул нөхөн сэргээлт төлөвлөөгүй болно.

10.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон нөлөөллийн бүсэд бусдын эзэмшлийн болон өмчийн газар байхгүй, айл өрх байхгүй тул нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

10.1.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн эхний жилд Палеонтологийн хайгуул судалгаа хийлгэх мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах, бичиг баримтын бүрдлээс шалтгаалан цаг хугацааны хувьд төслийн эхний жил буюу 2026 онд хийгдэх боломжгүй гэж үзсэн тул 2027 онд тусгасан болно.

10.1.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт № 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Өвөрхангай аймгийн БОГ-н хэрэгжүүлж буй аймгийн төвөөс 15 км-т байрлах Онгийн голын гүүрнээс урагш гол дагуу 40 га газарт татмын ойжуулалтын ажил хийх	Биологийн олон янз байдал ургамал мод бутыг хамгаалах хашаажуулалтын ажилд санхүүжилтээр хамран ажиллах	-	-	5,000,000	5,000,000	2026 онд	Өвөрхангай аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 187 тоот дугаартай албан бичиг
		Нийт дүн				5,000,000		

10.1.6. Тэрбум мод тарих төлөвлөгөө

“Баярсгоулд” ХХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигийн 2-т заасан тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд жил бүр 500 ш мод тарихаар төлөвлөсөн. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих газрыг сонгохдоо БОУАӨЯ-ны Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний 2026 оны 07-р сарын 01-ний өдрийн 12-р салбар хуралдааны мэргэжлийн зөвлөлөөс ирүүлсэн саналын дагуу “Онгийн голын гүүрнээс урагш гол дагуу 40 га газарт татмын ойжуулалтын ажил” гүйцэтгэж



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

буй талбай дээр боломжтой нөхцөлд төсөл хэрэгжүүлэгч өөрийн хөрөнгөөр мод тарихаар сонгов. Энэхүү ажлын зардлыг тооцохдоо БОАЖ-ын сайд, Сангийн сайд нарын 2021 оны А/172,116 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын норматив”-ыг ашиглан тооцсон болно. Жил бүр тарих 500 ширхэг модыг MNS 5918:2023 “Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага” стандартын дагуу 1 га талбайд тарина гэж тооцов.

Хүснэгт № 5. Тэрбум мод тарих төлөвлөгөө

№	Мод тарих байршил	Тарих модны тоо, ширхэг	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /төгрөг/			Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Шилмүүст модтны суулгацаар ойжуулах, нөхөн сэргээх норматив	Тарьцаар ойжуулах, нөхөн сэргээсэн талбайн арчилгааны норматив	Нийт				
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Өвөрхангай аймгийн БОГ-н хэрэгжүүлж буй татмын ойжуулалтын ажил гүйцэтгэж буй талбайд	500	га	2,700,000	850,000	3,550,000	1	3,550,000	9 сард	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны А/58 зарлиг
								3,550,000		

10.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс шалтгаалж гэнэтийн осол гарахаас сэргийлж тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, үзлэг хийж засварлах, хянах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх шаардлагатай. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллаагүйн улмаас хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй гэнэтийн осол эрсдэлээс сэргийлж уурхайн ажил эхлэхийн өмнө тогтмол ажилчдын дунд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулдаг байх, болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н болон АУТөлөвлөгөөтэй байх шаардлагатай.

Хүснэгт № 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Гэнэтийн гал түймрийн аюулын үед үүсэх эрсдэл	Гал унтраах жижиг хэрэгсэл цэнэглэх, галын аюулын тухай самбар, тэмдэг, тэмдэглэгээг зохих газруудад байрлуулах	Уурхайн барилга байгууламж болон ил уурхай орчимд	10	50,000	500,000	Уурхайн ашиглалт эхлэхийн өмнө	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17)



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагатай хамтран уурхайн ажилчдын дунд сургалт зохион байгуулах	Ажилчид	1	300,000	300,000	2026 онд	-Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль -MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”
	Нийт				800,000		

10.1.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Баярсгоулд” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хүснэгт № 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Хог хаягдлын цэгийг битүүмжлэл сайтай байхаар байгуулж, хашаалах, цаашид шаардлагатай тохиолдолд сэргээн засварлах	Хогийн цэг	цэг	150,000	1	150,000	Уурхайн ашиглалт эхлэхийн өмнө	-Хог хаягдлын тухай хууль; -БОАЖ-ын сайдын А/433 тушаал “Ариун цэврийн тухай” хууль; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаал - Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/443 тушаал - Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 тушаал - Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/21 тушаал,
2.		Ахуйн хог хаягдлаа орон нутагтай үргэлжлүүлэн гэрээ байгуулан тээвэрлүүлэх	Ахуйн хатуу хог хаягдал	удаа	125,000	2	250,000	9, 10 сард	
3.	Аюултай	Аюултай хог хаягдлыг зориулалтын битүүмжилсэн саванд хадгалж, цуглуулах, аюултай хог хаягдал авдаг байгууллагатай гэрээлэн тогтсон хугацаанд зайлуулж байх	Хэрэглэсэн батарей, ажилласан тос, шатах тослох материал гэх мэт	удаа	450,000	1	450,000	10 сард	
4.	Шингэн хаягдал	Ариун цэврийн байгууламжыг MNS 5924:2015. Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага дагуу байгуулах	Ариун цэврийн байгууламж	цэг	650,000	1	650,000	Уурхайн ашиглалт эхлэхийн өмнө	
5.		Шингэн хаягдлыг ариун цэврийн байгууламжийн ёмкс >70% дүүрэх	Ариун цэврийн байгууламж	удаа	150,000	1	150,000	10 сард	



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		үед бохир соруулан зайлуулдаг байгууллагатай хамтран тухай бүрд зайлуулдаг байх.							
		Нийт					1,650,000		

10.1.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журмыг байгаль орчны мэргэжилтэн тогтоож мөрдөх, Байгаль хамгаалахад ОН-н иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах, БО-г хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах шаардлагатай

Хүснэгт № 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Cap 8	Cap 9	Cap 10		
	1	2	3	4	5	6	7
1	Ажилчдыг ХАБЭА-н жижиг хэрэгсэлээр хангах	700.0	+			Уурхайн удирдлага	-MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй -MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм
4	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	3,000.0	+	+	+	Уурхайн удирдлага	- Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 5-д заасны дагуу 5 жил тутамд хийлгэх
		3,700.0					

10.1.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Баярсгоулд” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа болон үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөлөх байдлын үнэлгээний нэг чухал баримт бичиг юм. ОХШХ нь БОХТ-тэйгөө нягт уялдсан байх бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Баярсгоулд” ХХК хариуцах болно.



Зураг № 2. Мониторингийн цэгийн зураглал

Хүснэгт № 9. Мониторингийн цэгүүд

ОХШХ-ийн мониторингийн цэгүүд		
Хөрсний шинжилгээний цэгүүд	102° 15' 18"	46° 32' 32.28"
	102° 15' 25.2"	46° 32' 10.5"
	102° 14' 54.6"	46° 32' 41.86"
Агаарын шинжилгээний цэгүүд	102° 15' 20.88"	46° 32' 10.5"
	102° 14' 30.12"	46° 32' 47.58"
	102° 15' 11.52"	46° 32' 27.13"
Усны шинжилгээний цэгүүд	102° 14' 18.24"	46° 32' 42.47"
	102° 15' 9.36"	46° 32' 4.81"
	102° 14' 27.6"	46° 32' 45.71"
Голын усны түвшний мониторинг	102° 15' 24.12"	46° 32' 8.52"
	102°16'20.20"	46°28'50.10"
	102°16'19.80"	46°30'25.10"
Ургамлын мониторингийн цэгүүд	102° 15' 41.4"	46° 31' 50.02"
	102° 15' 27"	46° 32' 1.64"
	102° 15' 30.6"	46° 32' 9.06"
	102° 16' 25.68"	46° 31' 38.5"
	102°13'35.63"	46°34'4.55"
	102°16'3.12"	46°31'10.77"

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Дээжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанар								
1	PM10, PM2.5, NO2 /азотын давхар исэл SO2/хүхэрлэг хий CO/ нүүрстөрөгчийн дутуу исэл	Ил уурхай, тээврийн зам, тунаах нуурын орчимд зонхилох салхины чиглэлд тус бүр 1 цэгээс, нийт 3 цэгээс	9 болон 10-р сард	6 дээж	35,000	280,000	Шинжилгээ хийлгэх зардал нийт - 210,000 төг, Лабораторийн ажилтан ирж хэмжилт хийх ажлын хөлс - 70,000 төг	-MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - MNS 6063:2010 Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ
Хөрсний чанар								
1	Аргохими	Уурхайн орчим, тээврийн зам, уурхайн хотхоны ойр орчмоос тус бүр 1 цэгээс, нийт 3 цэгээс	9 болон 10-р сард	6 дээж	25,000	150,000		-MNS 3985: 1987. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл -MNS 3310:1991. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
2	Хүнд металл	Ил уурхайн, тунаах нуурын орчмоос тус бүр 1 цэгээс, нийт 2 цэгээс	9 болон 10-р сард	4 дээж	25,000	100,000		
3	Эрүүл ахуй	Уурхайн хотхоны ойр орчимд 1 цэгээс	9 болон 10-р сард	2 дээж	25,000	50,000		
Усны чанар								
1	Ундны усны ерөнхий химийн найрлага	Голын усны насос орчимоос гольдролын дээр болон доороос, нийт 2 цэгээс	9 болон 10-р сард	4 дээж	40,000	160,000		- MNS 0900:2018. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ MNS ISO 5667-11:2024 Усны чанар. Сорьц авах. 11-р хэсэг: Газрын доорх уснаас сорьц авах заавар - MNS ISO 5667-4:2001 Байгаль орчин. Усны чанар. Дээж авах. 4-р хэсэг Байгалийн болон хиймэл нуураас дээж авах заавар
2	Усны хүнд металлын шинжилгээ	Тунаах нуур, эргэлтийн усан сангаас	9 болон 10-р сард	4 дээж	55,000	220,000		
	Голын усны түвшин бууралт	Бөөрөлжүүтийн голын 2 харуулын мэдээг авч хяналт хийх	9 болон 10-р сард	-	35,000	140,000	2 харуулын цэгийн мэдээг уурхайн олборлолт эхлэхийн өмнө болон тухайн жилийн ажил зогсох үед авах	
Ургамлын мониторинг								
1	Ургамлын мониторинг	БНС хийсэн талбайд 2 цэг, үйл ажиллагаанд өртөөгүй талбайд 2 цэг, тусгай зөвшөөрлийн гадна хяналтын 2 цэг, нийт 6 цэг	9-10 сард	-	-	2,700.0	Мэргэжлийн байгууллагатай хамтрах	
Амьтны аймаг								



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Дээжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
	Усны биологийн олон янз байдлын мониторинг	Бөөрөлжүүтийн гол Онгийн голд цутгах цэгээс 1 км радиуст	9-10 сард	-	-	2,000.0	Мэргэжлийн байгууллагаар хийлгэх	
	Нийт					5,800.0		

10.1.11. Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах хуваарь

Хүснэгт № 11. БОМТ-ий хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Өвөрхангай аймаг, Уянга сумын, Бөөрөлжүүт багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11, 12-р сард	Зардал тооцох шаардлагагүй	Уурхайн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	Багийн ИНХ-н байр
2	Өвөрхангай аймгийн БОГ, БОУАӨЯ	Цахимаар илгээх	Тухайн жилийн БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сарын 1-ний дотор	Зардал тооцох шаардлагагүй	Уурхайн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	Цахим
3	БОУАӨЯ	Цахимаар илгээх	Дараа жилийн БОМТ-ний тайлан	12-р сарын 31-ний дотор	Зардал тооцох шаардлагагүй	Уурхайн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	Цахим
4	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, ТЗБ-аас томилогдсон ажлын хэсэг	Газар дээрх хяналт шалгалт	Тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтийг дүгнүүлэх талаар	11 сард	Зардал тооцох шаардлагагүй	Уурхайн дарга, Байгаль орчны мэргэжилтэн, ТЗБ-аас томилогдсон ажлын хэсэг	Уурхай



БОМТ –НИЙ НИЙТ ЗАРДАЛ

Х.П. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт № 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2026 он
		төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16,030,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Төлөвлөөгүй
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5,000,000
4	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Төлөвлөөгүй
5	Тэрбум мод тарих төлөвлөгөө	3,550,000
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	800,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,650,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	5,800,000
9	Тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	3,700,000
Нийт		32,980,000



БҮЛЭГ XI. ГОЛ ҮР ДҮНГҮҮД БА НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг дэвсгэрт орших “Баярсгоулд” ХХК-ийн MV-018764 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бөөрөлжүүтийн гол алтны шороон болон үүсмэл ордыг ил аргаар ашиглах төсөлд 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 32,980,000 төгрөг гарахаар тооцоолсноос Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлыг 100% Байгаль орчин, нөхөн сэргээх санд байршуулах зайлшгүй шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон цаг хугацаанд нь хэрэгжүүлэх шаардлагатай.

“Бөөрөлжүүтийн гол алтны шороон болон үүсмэл ордыг ил аргаар ашиглах төсөл”-ийн алтны шороон ордын үйл ажиллагааны явцад хөрс хамгийн ихээр элэгдэл эвдрэлд орох учир нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг цаг тухайд бүрт мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн нөхцөлд энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоос гадна шинээр ажлын байр нэмэгдэх, орон нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байна.



ХИ. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын тоот тушаал, 2019 он
6. Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт орших Бөөрөлжүүтийн гол алтны шороон болон үүсмэл ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2026 он
7. Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт орших “Бөөрөлжүүтийн гол” нэртэй алтны шороон ордын хайгуулын шугам 8-9, 56-59 болон үүсмэл ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол, УБ, 2025 он
8. Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт орших “Бөөрөлжүүтийн гол” нэртэй алтны шороон болон үүсмэл ордыг ил аргаар ашиглах төслийн “Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан” УБ, 2025 он
9. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014 он

